



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 5/22

Модот

Ц.Ариунтуяаг ажилд томилох тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалт, Засгийн Газрын 2018 оны 382, 2019 оны 06, 2023 оны 240, 2024 оны 84, 238 дугаар тогтоол, Ц.Ариунтуяагийн бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цогтбаатарын Ариунтуяаг бага ангийн багшийн албан тушаалд 2025 оны 08 дугаар сарын 29-ны өдрөөс томилон ажиллуулсугай.

2. Ц.Ариунтуяагийн үндсэн цалинг ТҮБД-3 дугаар шатлал 1,484,000 (нэг сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 18 хувиар, анги даалтын нэмэгдлийг 10 хувиар, кабинетын нэмэгдлийг 5 хувиар, мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 40 хувиар, өдрийн хоолны олговор, холбогдох бусад нэмэгдлийг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Л.Ариунтунгалаг)-т зөвшөөрсүгэй.

3. Ц.Ариунтуяагийн мэргэжил, арга зүйгээр ханган, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүрэг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг танилцуулан, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулахыг сургалтын менежер (Д.Ариунаа) эд хөрөнгийг данс бүртгэлээр хүлээлгэн өгөхийг нярав (Г.Золбоо) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ

Д.ОТГОНДУЛАМ

